



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/55

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрүүл мэндийн шалтгааны улмаас эмчлүүлэхэд санхүүгийн дэмжлэг хүссэн Улаан-Уул сумын иргэн Ж.Батсүх 500.000 (Таван зуун мянган) төгрөг, гэр нь шатсан А.Батхуягт 1,000.000 (Нэг сая) төгрөг, санхүүгийн дэмжлэг хүссэн “Ган зэв” аймгийн харваачдын холбоо төрийн бус байгууллагаас Мөсөн сурын 2024 оны улсын аварга шалгаруулах 2 багийн 20 гаруй тамирчдын замын зардал 1,500.000 (Нэг сая таван зуун мянган)төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2.Дээрх зардлын 3,000.000 (Гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

